



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА ГОМБОЖАВЫН
ЗАНДАНШАТАР ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

20140411 № 5Г-1/43
танай _____-ны № _____-т

**Хуулийн төсөл өргөн
мэдүүлэх тухай**

Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгөхийг хүсье.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД



Л.ОЮУН-ЭРДЭНЭ

000244001477



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д. Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2024.04.11 № ХЭГ/723
танай _____-ны № _____-т


УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Д.ЭНХБАТ ТАНАА

**Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
хугацааг товлох тухай**

Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Хавсралт 47 хуудастай.



МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН

000245001136



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: <http://www.mof.gov.mn>

2024.04.11 № 01/2558

танай _____-ны № _____-т

**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД
С.ЧИНЗОРИГ ТАНАА**

Танаас ирүүлсэн Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрлийг үүгээр олгож байна.

Хүндэтгэсэн,

Б.ЖАВХЛАН

9761000977



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,

Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26 75 33,


Цахим шуудан: info@mojha.gov.mn,

Цахим хуудас: www.mojha.gov.mn

2024.04.11 № 1/1750
танай _____-ны № 7а/1457-т

**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД
С.ЧИНЗОРИГ ТАНАА**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



Б.ЭНХБАЯР


151601318
Документ 05-2024

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн хуралдааны 13 дугаар тэмдэглэлд:

“18.ХЭЛЭЛЦСЭН нь: Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг боловсруулах дараах үндэслэл, шаардлага байна.

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Засгийн газраас хүн амын өвчлөл нас баралтын тэргүүлэх шалтгааны нэг болж байгаа гепатитын вирусийн халдвараас сэргийлэх, уг халдварыг оношлох, эмчлэхэд анхаарал хандуулж олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Тухайлбал, 2011-2015 онд Халдварт өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр, Вируст гепатиттай тэмцэх сэргийлэх зорилтот хөтөлбөр, 2017-2021 онд “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд “Элэг бүтэн Монгол” арга хэмжээг хэрэгжүүлэн гепатитын D вирусийн халдвартай иргэдийг эмчилгээнд хамруулахаар тусгасан.

1.2.Практик шаардлага

Монгол Улс гепатит вирусийн халдварын тархалт өндөртэй орны тоонд ордог бөгөөд энэхүү халдвараас үүдэлтэй элэгний хатуурал, хорт хавдар нь хүн амын өвчлөл нас баралтын тэргүүлэх шалтгаан болж байна. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-аас хийсэн тооцооллоор манай улсад гепатитын D вирусийн халдвартай 60 гаруй мянган иргэн байх магадлалтай байна.

Эмийн чанар, аюулгүй байдлын хатуу зохицуулалттай хяналтын байгууллага болох Европын эмийн агентлагаас Булевиртид эмийг эмийн бүртгэлд албан ёсоор бүртгэж, гепатитын B, D вирусийн архаг халдварын эмчилгээнд хэрэглэх зөвшөөрөл олгосон. Үүнтэй уялдуулан манай улс гепатитын B, D вирусийн эмчилгээний заавраа шинэчлэн баталж 2024 оноос мөрдөж эхлээд байна.

Булевиртид эм нь 47 амин хүчлээс тогтсон нийлэг эм бөгөөд элэгний эсэд D вирус нэвтрэхийг саатуулах үйлчилгээтэй болно.

Гепатитын В, D вирусийн эмчилгээнд хэрэглэх Булевертид эмийн үнэ өндөр байгаатай холбоотойгоор тус эмчилгээ шаардлагатай иргэд эмчилгээнд хамрагдаж чадахгүй байна.

Эрүүл мэндийн яамнаас Булевертид эмийн албан ёсны патентыг эзэмшигч АНУ-ын "Gilead Sciences Inc" компанитай эмийн үнийг хэд дахин бууруулах талаар яриа хэлэлцээг үргэлжлүүлэн хийж байна.

Эрүүл мэндийн тухай хуулийн 4.1.2-д "хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг ялгаварлан гадуурхахгүйгээр тэгш, хүртээмжтэй үзүүлэх" гэж заасны дагуу гепатитын В ба D вирусийн хавсарсан халдвартай иргэдэд шаардлагатай эмийн үнийг бууруулж иргэдэд учрах санхүүгийн дарамтыг багасгах зорилгоор Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлага бий болж байна.

Хоёр.Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслийг гурван зүйлтэй байхаар боловсруулна. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлээр Гепатитын D вирусийн эмчилгээнд хэрэглэх зорилгоор импортлох Булевертид эмийг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх талаар, 2 дугаар зүйлээр нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөгдөх эмийн жагсаалтыг Засгийн газар батлахаар, 3 дугаар зүйлээр хуулийг дагаж мөрдөх хугацааг тус тус зохицуулахаар тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсанаар үүсэх нийгэм, эдийн засгийн үр дагавар, гарах үр дүн

Хуулийн төсөл батлагдсанаар дараах эерэг үр дүн гарна. Гепатитын D вирусийн халдвартай иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж сайжирч, хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаанд багтаж байгаа элэгний хатуурал, элэгний хорт хавдрын шалтгаант нас баралт буурна. Үүний зэрэгцээ иргэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авахад учрах санхүүгийн дарамт буурна.

Дөрөв.Хууль гарсантай холбогдуулан шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хууль тогтоомжийн талаар

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжтой нийцэж байгаа бөгөөд төсөл батлагдсантай холбогдуулан шинээр боловсруулах болон нэмэлт, өөрчлөлт орох шаардлагатай хууль тогтоомжууд байхгүй болно.

-----oOo-----

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

ГЕПАТИТЫН D ВИРУСИЙН ЭМЧИЛГЭЭНД ХЭРЭГЛЭХ ЗОРИЛГООР ИМПОРТЛОХ БУЛЕВИРТИД ЭМИЙГ НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

2024.03.29-ний өдөр

Монгол Улсын Засгийн газраас хүн амын өвчлөл нас баралтын тэргүүлэх шалтгааны нэг болж байгаа гепатитын вирусийн халдвараас сэргийлэх, уг халдварыг оношлох, эмчлэхэд анхаарал хандуулж олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Тухайлбал, 2011-2015 онд Халдварт өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр, Вируст гепатиттай тэмцэх сэргийлэх зорилтот хөтөлбөр, 2017-2021 онд “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд “Элэг бүтэн Монгол” арга хэмжээг хэрэгжүүлэн гепатитын D вирусийн халдвартай иргэдийг эмчилгээнд хамруулахаар тусгасан.

Монгол Улс гепатитын вирусийн халдварын тархалт өндөртэй орны тоонд ордог бөгөөд энэхүү халдвараас үүдэлтэй элэгний хатуурал, хорт хавдар нь хүн амын өвчлөл нас баралтын тэргүүлэх шалтгаан болж байна.

Гепатитын вирусийн А, В, С, D, E гэсэн 5 төрөл байдаг. Тэдгээрийн халдвар дамжих зам, өвчний явц, газарзүйн тархалт, урьдчилан сэргийлэх арга зэрэг нь хоорондоо ялгаатай бөгөөд В, С вирус нь бэлгийн замаар, тарилга хийх, шивээс хийлгэх зэргээр арьс салстын гэмтсэн үед, халдвартай цус, цусан бүтээгдэхүүнтэй ажиллах үед, халдвартай эхээс хүүхдэд халдвар дамждаг.

Гепатитын D вирусийн халдвар ихэвчлэн гепатитын В вирусийн халдвартай хавсардаг. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-аас хийсэн тооцооллоор манай улсад гепатитын D вирусийн халдвартай 60 гаруй мянган иргэн байх магадлалтай байна.

Гепатитын D вирусийн халдварыг эмчлэхэд Булевертид эм үр дүнтэй хэмээн гэж үзэж байна. Булевертид нь 47 амин хүчлээс тогтсон нийлэг эм бөгөөд элэгний эсэд D вирус нэвтрэхийг саатуулах үйлчилгээтэй.

Эмийн чанар, аюулгүй байдлын хатуу зохицуулалттай хяналтын байгууллага болох Европын эмийн агентлагаас Булевертид эмийг эмийн бүртгэлд албан ёсоор бүртгэж, гепатитын В, D вирусийн архаг халдварын эмчилгээнд хэрэглэх зөвшөөрөл олгосон. Үүнтэй уялдуулан манай улс Булевертид эмийг өнчин эмийн жагсаалтад оруулж, гепатитын В, D вирусийн эмчилгээний заавраа шинэчлэн баталж, 2024 оноос мөрдөж эхлээд байна. Гэвч гепатитын В, D вирусийн эмчилгээнд хэрэглэх Булевертид эмийн үнэ өндөр байгаатай холбоотойгоор тус эмчилгээ шаардлагатай иргэд эмчилгээнд хамрагдаж чадахгүй байна.

Булевертид эмийг анх ОХУ нээсэн бөгөөд эмийн патентаа АНУ-ын Gilead Science компанид зарснаар Gilead Science компани нь тус эмийн ганц патент эзэмшигч нь болсон. Оюуны өмчийг хамгаалах эрхзүйн зохицуулалтын хүрээнд ОХУ зөвхөн дотооддоо хэрэглэх эрхийг хадгалж үлдсэн ба гадаад улс орнуудад экспортлох боломжгүй байна.

Эрүүл мэндийн яамнаас Булевертид эмийн албан ёсны патентыг эзэмшигч АНУ-ын "Gilead Sciences Inc" компанитай эмийн үнийг хэд дахин бууруулах талаар яриа хэлэлцээг үргэлжлүүлэн хийж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний 2.1.1.5-д заасан "Элэг бүтэн Монгол" арга хэмжээний 2023-2024 оны санхүүжилтээс 12.8 тэрбум төгрөгийг тус эмийг худалдан авахад зарцуулахаар төсөвлөөд байна.

Эрүүл мэндийн тухай хуулийн 4.1.2-д "хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг ялгаварлан гадуурхахгүйгээр тэгш, хүртээмжтэй үзүүлэх" гэж заасны дагуу гепатитын В ба Д вирусийн хавсарсан халдвартай иргэдэд шаардлагатай эмийн үнийг бууруулж иргэдэд учрах санхүүгийн дарамтыг багасгах зорилгоор Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлага бий болж байна.

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

ГЕПАТИТЫН D ВИРУСИЙН ЭМЧИЛГЭЭНД ХЭРЭГЛЭХ ЗОРИЛГООР ИМПОРТЛОХ БУЛЕВИРТИД ЭМИЙГ НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

2024.03.29-ний өдөр

Монгол Улс гепатит вирусийн халдварын тархалт өндөртэй орны тоонд ордог бөгөөд энэхүү халдвараас үүдэлтэй элэгний хатуурал, хорт хавдар нь хүн амын өвчлөл нас баралтын тэргүүлэх шалтгаан болж байна. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-аас хийсэн тооцооллоор манай улсад гепатитын D вирусийн халдвартай 60 гаруй мянган иргэн байх магадлалтай байна.

Эмийн чанар, аюулгүй байдлын хатуу зохицуулалттай хяналтын байгууллага болох Европын эмийн агентлагаас Булевирийд эмийг эмийн бүртгэлд албан ёсоор бүртгэж, гепатитын B, D вирусийн архаг халдварын эмчилгээнд хэрэглэх зөвшөөрөл олгосон. Үүнтэй уялдуулан манай улс гепатитын B, D вирусийн эмчилгээний заавраа шинэчлэн баталж 2024 оноос мөрдөж эхлээд байна.

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 22.7.5-д “Өнчин эм” -ийг улсын бүртгэлд бүртгэхгүйгээр импортлох талаар заасан байдаг. Хүний эмийн зөвлөлийн 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн хурлын 05 дугаар шийдвэрээр “Булевирийд” эмийг өнчин эмийн жагсаалтад оруулахыг дэмжиж, Эрүүл мэндийн сайдын 2023 оны 7 дугаар сарын 5-ны “Өнчин эмийн жагсаалтад нэмэлт өөрчлөлт оруулах” тухай А/250 дугаар тушаалаар “Булевирийд” эмийг өнчин эмийн жагсаалтад оруулсан.

Гепатитын B, D вирусийг бүрэн төгс эмчилдэг эм, эмчилгээ дэлхийн шинжлэх ухаанд хараахан гараагүй байна. Европын элэг судлалын холбооноос 2023 онд гепатитын D вирусийн оношилгоо, эмчилгээний заавар гаргаж Пег-интерферон альфа болон Булевирийд эмийн эмчилгээг зөвлөсөн. 2020 оны 7 дугаар сард Европын эмийн агентлагаас MYR301 эмнэлзүйн судалгааны явцын үр дүнд тулгуурлан гепатитын D вирусийн халдвартай өвчтөнүүдийн эмчилгээнд Булевирийд 2 мг тарилга хэлбэрт нөхцөлт зөвшөөрөл олгосон. Дээрх нөхцөлт зөвшөөрөлд Булевирийд 2 мг тунг өдөрт нэг удаа (24 цаг± 4 цаг тутамд) арьсан дор тарьж хэрэглэхээр заасан байна. Түүнчлэн, Булевирийд эм нь ОХУ-д Мирклудекс Б® (Myrcludex B), АНУ-ын “Gilead Science Inc” Hepcludex гэж бүртгэгдсэн. ОХУ анх Булевирийд эмийг нээсэн бөгөөд эмийн патентаа АНУ-ын Gilead Science компанид зарснаар Gilead Science компани нь тус эмийн ганц патент эзэмшигч нь болсон. Оюуны өмчийг хамгаалах эрхзүйн зохицуулалтын хүрээнд ОХУ зөвхөн дотооддоо хэрэглэх эрхийг хадгалж үлдсэн ба гадаад улс орнуудад экспортлох боломжгүй байна. Булевирийд эм нь D вирусийг элэгний эс рүү орохыг саатуулах өвөрмөц үйлчлэлтэй, дэлхий дээр ганц патент эзэмшигчтэй тул бусад ижил төстэй эмүүдтэй харьцуулах боломжгүй байна. Булевирийд эм нь 47 амин хүчлээс тогтсон нийлэг эм бөгөөд элэгний эсэд D вирус нэвтрэхийг саатуулах үйлчилгээтэй болно.

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 23.2-т “Эмийн чанарыг фармакопей болон түүнтэй дүйцэхүйц баримт бичгийг үндэслэн баталгаажуулна”, 15.1-д “Эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллага эм, эмнэлгийн хэрэгсэл

импортлох, экспортлоход эмийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрөл авна.”, 22 дугаар зүйлийн 22.7.1, 22.7.4-22.7.7 дахь заалтад заасан “эм, эмнэлгийн хэрэгсэл, дээж, загварт лиценз авахад эм, эмнэлгийн хэрэгслийн тун, тоо хэмжээ, хэлбэр, үйлдвэрлэгч, гарал үүсэл, үнийн тухай мэдээлэл агуулсан, 2.2.7-д заасан Эмийн дээж импортлоход эм үйлдвэрийн зохистой дадал /GMP/-ын талаар албан ёсны баримт бичгийг бүрдүүлж ирүүлнэ” гэж заасны дагуу Булевиртид (Хэпклюдекс) эмийг Монгол Улсын хилээр оруулж ирэх тохиолдол бүрд тухайн цувралыг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулгын газраас импортын бүртгэл олгохдоо үйлдвэрлэгч компаниас ирүүлсэн холбогдох баримт бичгийг үндэслэн чанарын баталгаажилт, хяналтыг хангана.

Гепатитын В, D вирусийн эмчилгээнд хэрэглэх Булевиртид эмийн үнэ өндөр байгаатай холбоотойгоор тус эмчилгээ шаардлагатай иргэд эмчилгээнд хамрагдаж чадахгүй байна. ОХУ-ын гепатитын D вирусийн эмчилгээний эмнэлзүйн зааварт эмчилгээний үргэлжлэх хугацаа 48 долоо хоног гэж заасан байна. Мөн ОХУ-ын Эрүүлийг хамгаалах яамнаас эмийн үнийг 2023 онд 167,000 рубль гэж тогтоосныг Эрүүл мэндийн сайд нарын хэлэлцсэний дагуу Монгол Улсаас 1,000 хүн ОХУ-д эмчилгээнд хамруулсан тохиолдолд 145,000 рубль хүртэл бууруулах боломжтой тухай мэдэгдсэн. Үүн дээр үндэслэн нийт 1,000 хүний 48 долоо хоногийн эмчилгээний зардлыг тооцоолон гаргасан.

Тус эмийн үнэ манай улсын хувьд дундаж цалингаас 5 дахин өндөр, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс 13 дахин өндөр байгаа нь тус эмчилгээнд хамрагдах боломж тун хомс байгааг харуулж байна. Иймд, Булевиртид эмийг Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.1-д заасны дагуу Эрүүл мэндийн даатгалын сангаас хариуцах эсэх талаар одоогоор шийдвэрлээгүй байна. Энэхүү эмийн хүртээмж олон улсад сайжирч, Дэлхийн улс орнуудад өргөнөөр хэрэглэх тохиолдолд эмийн үнэ буурна хэмээн үзэж байна. Одоогоор 2 улсын хоорондын зөвшилцөл, хэлцлийн хүрээнд эмийн үнийг бууруулах талаар ажиллаж байна.

ОХУ-д эмчилгээнд хамрагдах иргэд эмийн зардлаас гадна замын зардал, ОХУ-д байх хугацаанд гарах байр, унаа, хоолны зардал, оношилгоо, шинжилгээний төлбөрийг сар бүр төлөх шаардлага гарч байна. Энэхүү нэмэлт зардал нь 1.500.000 төгрөг орчим болно. Эмийн үнийн асуудлаас гадна дээрх нэмэлт зардлыг бууруулах зорилгоор ОХУ-ын Эрүүлийг хамгаалахын сайд М.А.Мурашкотой 2024 оны 2 дугаар сарын 16-ны өдөр Буриад Улсын Улан-Үд хотноо уулзалт, хэлэлцээр хийсэн. Үүний дүнд ОХУ-д байх хугацаанд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний асуудлыг бүрэн хариуцах, хөнгөлөлттэй үнэ бүхий байранд байрлуулах, цаг харгалзахгүй, хүлээгдэл, чирэгдэлгүй үйлчлэх, эмийн хадгалалт, тээвэрлэлтийг зохион байгуулахаар тогтсон.

АНУ-ын “Gilead Science Inc” компани нь ХДХВ, ДОХ, элэгний В,С вирус, эбола, ковидын вирус, хавдрын болон мөөгөнцрийн эсрэг эмүүдийг дэлхийн зах зээлд нийлүүлж байна. Тус үйлдвэрлэгчийн элэгний В, С вирусийн зарим эм нь Манай улсад бүртгэгдсэн байдаг бөгөөд Булевиртид эмийн цорын ганц патент эзэмшигч юм. Тус компани нь 2023-2024 онд Монгол Улсад нийт 30 өвчтөнд хэрэглэх тариаг үе шаттайгаар нийлүүлж байна. Эрүүл мэндийн яамнаас Булевиртид эмийн албан ёсны патентыг эзэмшигч АНУ-ын “Gilead Sciences Inc” компанитай эмийн үнийг хэд дахин бууруулах талаар яриа хэлэлцээг үргэлжлүүлэн хийж байна. Цаашид

Холбооны Бүгд Найрамдах Герман улсаас Монгол улсад зээлсэн 29 сая еврог “Debt to Health” хөтөлбөрийн хүрээнд Глобал сангаар дамжуулан Монгол улсын ДОХ, сүрьеэтэй тэмцэх, эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр 2025-2030 онд графикийн дагуу олгохоор болсон. Энэ санхүүжилтийн хүрээнд гепатитын В, D вирусийн оношилгоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжихээр төлөвлөж байна.

Иймд Эрүүл мэндийн тухай хуулийн 4.1.2-д “хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг ялгаварлан гадуурхахгүйгээр тэгш, хүртээмжтэй үзүүлэх” гэж заасны дагуу гепатитын В ба D вирусийн хавсарсан халдвартай иргэдэд шаардлагатай эмийн үнийг бууруулж иргэдэд учрах санхүүгийн дарамтыг багасгах зорилгоор Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлага бий болж байна.

Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөгдөх хуулийн төслийг гурван зүйлтэй байхаар боловсруулсан. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлээр Гепатитын D вирусийн эмчилгээнд хэрэглэх зорилгоор импортлох Булевиртид эмийг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх талаар, 2 дугаар зүйлээр нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөгдөх эмийн жагсаалтыг Засгийн газар батлахаар, 3 дугаар зүйлээр хуулийг дагаж мөрдөх хугацааг тус тус тусгасан.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлээр Гепатитын В ба D вирусийн хавсарсан халдвартай иргэдэд шаардлагатай эмийн үнийн бууруулах зорилгоор нэмэгдсэн өртгийн албан татвар болох 10 хувийн татварыг чөлөөлөх талаар, Хуулийн төслийн 2 дугаар зүйлээр нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх эмийн жагсаалтыг “Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем /БТКУС/”-ийн ангиллын дагуу Засгийн газар тогтоохоор, Хуулийн төслийн 3 дугаар зүйлээр Засгийн газрын тогтоолоор батлагдсан жагсаалт туссан эмийг 2027 оны 1 дүгээр сарын 1-ний хүртэл нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх талаар тус тус тусгасан.

-----oOo-----

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гепатитын D вирусийн эмчилгээнд хэрэглэх зорилгоор импортлох Булевиртид эмийг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан эмийн жагсаалтыг "Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем /БТКУС/"-ийн ангиллын дагуу Монгол Улсын Засгийн газар батална.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2027 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр хүртэл дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДАЛСАН
СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

УЛААНБААТАР ХОТ 2024 ОН

АГУУЛГА

Гарчиг

НЭГ. Асуудалд дүн шинжилгээ хийх

1.1. Асуудлын хамрах хүрээ

1.2. Тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй
этгээдүүд

1.3. Асуудлыг үүсгэж буй учир шалтгаан

ХОЁР. Асуудлыг шийдвэрлэх зорилго

2.1. Гол зорилго, зорилт

ГУРАВ. Асуудлыг зохицуулах хувилбарууд, тэдгээрийн харьцуулалт

3.1. Асуудлыг зохицуулах хувилбарууд

3.2. Зохицуулалтын хувилбаруудын эерэг болон сөрөг талыг харьцуулсан
тухай

3.3. Хамгийн үр дүнтэй хувилбарын тухай

ДӨРӨВ. Зохицуулалтын хувилбарын үр нөлөөний талаар

4.1. Хүний эрх, нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

4.1.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

4.1.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

4.1.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө

4.1.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

4.2. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад
хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэх талаар

ТАВ. Дүгнэлт

ЗУРГАА. Тухайн зохицуулалтын талаарх олон улсын болон бусад улсын эрх зүйн
зохицуулалтын харьцуулсан судалгаа

ДОЛОО. Зөвлөмж

НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ

Гепатитын D вирусийн эмчилгээнд хэрэглэх зорилгоор импортлох Булевиртид эмийг Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл боловсруулахад Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал” /цаашид “Урьдчилан тандан судлах” гэх/-ын дагуу дараах үе шаттай Урьдчилан тандан судлах судалгааг хийлээ.

1.1. Асуудлын хамрах хүрээ.

Монгол Улс гепатит вирусийн халдварын тархалт өндөртэй орны тоонд ордог бөгөөд энэхүү халдвараас үүдэлтэй элэгний хатуурал, хорт хавдар нь хүн амын өвчлөл нас баралтын тэргүүлэх шалтгаан болж байна. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-аас хийсэн тооцооллоор манай улсад гепатитын D вирусийн халдвартай 60 гаруй мянган иргэн байх магадлалтай байна.

Эмийн чанар, аюулгүй байдлын хатуу зохицуулалттай хяналтын байгууллага болох Европын эмийн агентлагаас Булевиртид эмийг эмийн бүртгэлд албан ёсоор бүртгэж, гепатитын B, D вирусийн архаг халдварын эмчилгээнд хэрэглэх зөвшөөрөл олгосон. Үүнтэй уялдуулан манай улс гепатитын B, D вирусийн эмчилгээний заавраа шинэчлэн баталж 2024 оноос мөрдөж эхлээд байна.

Гепатитын B, D вирусийн эмчилгээнд хэрэглэх Булевиртид эмийн үнэ өндөр байгаатай холбоотойгоор тус эмчилгээ шаардлагатай иргэд эмчилгээнд хамрагдаж чадахгүй байна.

Гепатитын D вирусийн эмчилгээнд хэрэглэх зорилгоор импортлох Булевиртид эмийг Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлснөөр Гепатитын D вирусийн халдвартай иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж сайжирч, хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаанд багтаж байгаа элэгний хатуурал, элэгний хорт хавдрын шалтгаант нас баралт буурна. Үүний зэрэгцээ иргэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авахад учрах санхүүгийн дарамт буурах ач холбогдолтой.

1.2. Тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй этгээдүүд

Дээрх асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөж байгаа бүлэг, иргэд, аж ахуй нэгжийг дараах байдлаар тодорхойлж байна:

Манай улсад 2023 оны байдлаар нийт 426 эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллага тусгай зөвшөөрөлтэй байгаагаас, эм ханган нийлүүлэх байгууллага 283 байна. 2,573 эмийн сан (УБ-1471, Орон нутагт 1102), 43 эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүн, ариутгал халдваргүйтгэлийн бодис, протезын үйлдвэр байна. Үүнээс 26 эмийн үйлдвэр байна.¹ Гепатитын D

¹ Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын тайлан

вирусийн эмчилгээнд хэрэглэх зорилгоор импортлох Булевиртид эмийг албан татвараас чөлөөлснөөр эдгээр байгууллагын хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөхгүй.

Гепатитын В, D вирусийн эмчилгээнд хэрэглэх Булевиртид эмийн үнэ өндөр байгаатай холбоотой тус эмчилгээ шаардлагатай иргэд эмчилгээнд хамрагдаж чадахгүй байна. Иймд Монгол Улсын иргэд боломжийн үнэтэй эм, эмнэлгийн хэрэгслээр хангагдах эрх хөндөгдөнө.

1.3. Асуудлыг үүсгэж буй учир шалтгаан, дүн шинжилгээ хийх, цар хүрээ

Монгол Улсын Засгийн газраас хүн амын өвчлөл нас баралтын тэргүүлэх шалтгааны нэг болж байгаа гепатитын вирусийн халдвараас сэргийлэх, уг халдварыг оношлох, эмчлэхэд анхаарал хандуулж олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Тухайлбал, 2011-2015 онд Халдварт өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр, Вируст гепатиттай тэмцэх сэргийлэх зорилтот хөтөлбөр, 2017-2021 онд “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд “Элэг бүтэн Монгол” арга хэмжээг хэрэгжүүлэн гепатитын D вирусийн халдвартай иргэдийг эмчилгээнд хамруулахаар тусгасан.

Монгол Улс гепатитийн вирусийн халдварын тархалт өндөртэй орны тоонд ордог бөгөөд энэхүү халдвараас үүдэлтэй элэгний хатуурал, хорт хавдар нь хүн амын өвчлөл нас баралтын тэргүүлэх шалтгаан болж байна.

Гепатитын вирусийн А, В, С, D, E гэсэн 5 төрөл байдаг. Тэдгээрийн халдвар дамжих зам, өвчний явц, газарзүйн тархалт, урьдчилан сэргийлэх арга зэрэг нь хоорондоо ялгаатай бөгөөд В, С вирус нь бэлгийн замаар, тарилга хийх, шивээс хийлгэх зэргээр арьс салстын гэмтсэн үед, халдвартай цус, цусан бүтээгдэхүүнтэй ажиллах үед, халдвартай эхээс хүүхдэд халдвар дамждаг.

Гепатитын D вирусийн халдвар ихэвчлэн гепатитийн В вирусийн халдвартай хавсардаг. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-аас хийсэн тооцооллоор манай улсад гепатитын D вирусийн халдвартай 60 гаруй мянган иргэн байх магадлалтай байна.

Иймд Эрүүл мэндийн тухай хуулийн 4.1.2-д “хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг ялгаварлан гадуурхахгүйгээр тэгш, хүртээмжтэй үзүүлэх” гэж заасны дагуу гепатитын В ба D вирусийн хавсарсан халдвартай иргэдэд шаардлагатай эмийн үнийг бууруулж иргэдэд учрах санхүүгийн дарамтыг багасгах зорилгоор Нэмэгдсэн өртгийн татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлага бий болж байна.

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГО

2.1. Гол зорилго, зорилт

Хуулийн зорилго: "Гепатитын D вирусийн эмчилгээнд хэрэглэх зорилгоор импортлох Булевиртид эмийг Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлснөөр иргэдэд учрах санхүүгийн дарамтыг бууруулж, эмнэлгийн тусламж үйлчилгээний тасралтгүй байдлыг хангахад чиглэгдэнэ."

ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЗЕРЭГ БОЛОН СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

3.1 болон 3.2. Зохицуулалтын хувилбарууд түүний зэрэг, сөрөг талыг харьцуулсан байдал

№	ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАР	ЗОРИЛГОД ХҮРЭХ БАЙДАЛ	ЗАРДАЛ, ҮР ӨГӨӨЖИЙН ХАРЬЦАА	ҮР ДҮН
1	Тэг хувилбар	Асуудлын зорилго хангагдахгүй учраас тэг зохицуулалт манай тохиолдолд шаардлагагүй.	Зардал гарахгүй, импортлогч байгууллагад татварын дарамт байсаар байна.	Сөрөг үр дагавартай
2	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх	Албан татвараас чөлөөлөх асуудал энэ зохицуулалтын хувилбарын хувьд оновчгүй буюу шаардлагагүй.	Хэвлэл мэдээлэл, олон нийтэд таниулахтай холбоотой сургалт, нэвтрүүлэг, ухуулга хийх нэмэлт зардал гарах боловч асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаврыг бууруулж чадахгүй.	Үр дүнгүй
3	Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх	Эдийн засгийн арга хэрэгслээр зохицуулах боломжгүй.	Зардал шаардагдана. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаврыг бууруулж чадахгүй	Тодорхой үр дүнд хүрэхгүй
4	Төрөөс санхүүгийн интервенци хийх	Асуудал үүссэн гол шалтгаантай холбоогүй тул зорилгод хүрэх боломжгүй	Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаврыг бууруулж чадахгүй	Үр дүнгүй

5	Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх боломжгүй.	Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаврыг арилгаж чадахгүй	Үр дүнгүй
6	Захиргааны шийдвэр гаргах	Бүрэн шийдвэрлэж чадахгүй.	Асуудлыг үүсгэж байгаа шалтгааныг арилгахад цогцоор нөлөөлж сөрөг үр дагаврыг бүрэн бууруулж чадахгүй.	Тодорхой үр дүнд хүрэхгүй.
7	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Гепатитын D вирусийн эмчилгээнд хэрэглэх зорилгоор импортлох Булевиртид эмийг Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлснөөр иргэдэд учрах санхүүгийн дарамтыг бууруулж, эмнэлгийн тусламж үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах боломж бүрдэх тул асуудлыг шийдвэрлэх бөгөөд зорилгод хүрэх боломжтой.	Зардал гарах боловч энэ хувилбар нь асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг шийдвэрлэхэд чухал нөлөө үзүүлэх боломжтой.	Үр дүнтэй

3.3. Хамгийн үр дүнтэй хувилбарын тухай

Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх замаар иргэд, олон нийтийг мэдээллээр хангах, зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх, эсхүл төрөөс санхүүгийн интервенци хийх, захиргааны шийдвэр гаргаснаар тухайн асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг шийдвэрлэж, дэвшүүлсэн зорилгод хүрэх боломжгүй.

Иймд асуудлын мөн чанар, цар хүрээг харгалзан Гепатитын D вирусийн эмчилгээнд хэрэглэх зорилгоор импортлох Булевиртид эмийг Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх хуулийн төслийг боловсруулах шаардлагатай байна.

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРЫН ҮР НӨЛӨӨНИЙ ТАЛААР

4.1. Хүний эрх, нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

4.1.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
------------------	------------------	---------	---------

1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх	1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.1. Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	Үгүй	Хүний эрхийн зөрчлийг агуулаагүй
	1.1.2. Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулаагүй, тэгш хандлагатай
	1.1.3. Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Олон нийтийн эрхийг аливаа хэлбэрээр зөрчөөгүй
	1.2. Оролцоог хангах			
	1.2.1. Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм	Үгүй	Бодит нөхцөл байдлыг судалсан.
	1.2.2. Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Эрх, хууль ёсны ашиг сонирхолд нөлөөлөх эсэхийг тогтоож, үр нөлөөг тооцсон.
	1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариуцлага			
	1.3.1. Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхүүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм	Үгүй	Хүн бүрд олгогдсон тэгш боломж, тэгш эрхийн баталгаа бүрдэнэ

	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмын талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Хүн бүр тэгш эрхтэй байх нөхцөл, боломжийг бүрдүүлэхэд чиглүүлнэ.
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм	Үгүй	Зохицуулалт байхгүй
2.Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн хязгаарлалт хийгдэхгүй.
	2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Тийм	Үгүй	-
3.Эрх агуулагч	3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	-
	3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	-
	3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм	Үгүй	-
	3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг	Тийм	Үгүй	Энэ төрлийн зохицуулалт байх шаардлагагүй.

	тусгах эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй)			
4.Үүрэг хүлээгч	4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Төр татвараас чөлөөлөх үүрэг хүлээж байна.
5.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1.Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм	Үгүй	Жендэрийн тэгш байдлыг зөрчих зохицуулалт байхгүй.
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Хөдөлмөрийн болон Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хуульд заасан үйлчлэл хамаарна

4.1.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуудлууд	Хариулт		Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Тийм	Үгүй	
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг Монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм	Үгүй	
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Тийм	Үгүй	
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа иргэн, аж ахуйн	Тийм	Үгүй	

	нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх			
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Тийм	Үгүй	
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Тийм	Үгүй	
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Тийм	Үгүй	
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Тийм	Үгүй	
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Тийм	Үгүй	
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Тийм	Үгүй	
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	
6.Инноваци болон	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл	Тийм	Үгүй	

судалгаа шинжилгээ	гаргах асуудлыг дэмжих эсэх			
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм	Үгүй	
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм	Үгүй	
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Иргэдэд учрах санхүүгийн дарамтыг багасгах
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм	Үгүй	Татварын хөнгөлөлт чөлөөлөлт үзүүлснээр улсын төсвийн орлого бүрдүүлэлтийг хасаж байгаа боловч Гепатитын D вирусийн халдвартай иргэд эмнэлгийн тусламж үйлчилгээ авч, ажил хөдөлмөрөө эрхлэх боломж бүрдэнэ.
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	-
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	-
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	-
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Тийм	Үгүй	
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм	Үгүй	

10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм	Үгүй	
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	

4.1.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
		Тийм	Үгүй	
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм	Үгүй	-
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхтгол бий болгох эсэх	Тийм	Үгүй	-
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Татварын хөнгөлөлтөөр төрөөс дэмжлэг үзүүлнэ.
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм	Үгүй	
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм	Үгүй	
3.Нийгмийн тодорхой	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	

бүлгийг хамгаалах асуудал	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	Тийм	Үгүй	
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	

	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	

4.1.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
		Тийм	Үгүй	
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	
2.Зам тээвэр,	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Тийм	Үгүй	

түлш, эрчим хүч	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Тийм	Үгүй	
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сэргээр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сэргээр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сэргээр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сэргээр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Тийм	Үгүй	
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Тийм	Үгүй	
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	

4.2. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэх талаар

Гепатитын D вирусийн эмчилгээнд хэрэглэх зорилгоор импортлох Булевиртид эмийг Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулсан.

ТАВ. ДҮГНЭЛТ

Хууль тогтоомжийн төсөл боловсруулах зохицуулалтын хувилбар нь одоогийн нөхцөлд дэвшүүлсэн зорилгыг хангах хамгийн боломжит хувилбар бөгөөд Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомж, хүний эрх, нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө нь байж болох хэмжээнээс хэтрэхгүй болно.

Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх замаар иргэд, олон нийтийг мэдээллээр хангах, зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх, эсхүл төрөөс санхүүгийн интервенци хийх, захиргааны шийдвэр гаргаснаар тухайн асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг шийдвэрлэж, дэвшүүлсэн зорилгод хүрэх боломжгүй.

ЗУРГАА.ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА.

Гепатитын D вирусийн халдвар ихэвчлэн гепатитийн B вирусийн халдвартай хавсардаг. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-аас хийсэн тооцооллоор манай улсад гепатитын D вирусийн халдвартай 60 гаруй мянган иргэн байх магадлалтай байна.

Гепатитын D вирусийн халдварыг эмчлэхэд Булевиртид эм үр дүнтэй хэмээн гэж үзэж байна. Булевиртид нь 47 амин хүчлээс тогтсон нийлэг эм бөгөөд элэгний эсэд D вирус нэвтрэхийг саатуулах үйлчилгээтэй.

Эмийн чанар, аюулгүй байдлын хатуу зохицуулалттай хяналтын байгууллага болох Европын эмийн агентлагаас Булевиртид эмийг эмийн бүртгэлд албан ёсоор бүртгэж, гепатитын B, D вирусийн архаг халдварын эмчилгээнд хэрэглэх зөвшөөрөл олгосон. Үүнтэй уялдуулан манай улс Булевиртид эмийг өнчин эмийн жагсаалтад оруулж, гепатитын B, D вирусийн эмчилгээний заавраа шинэчлэн баталж, 2024 оноос мөрдөж эхлээд байна. Гэвч гепатитын B, D вирусийн эмчилгээнд хэрэглэх Булевиртид эмийн үнэ өндөр байгаатай холбоотойгоор тус эмчилгээ шаардлагатай иргэд эмчилгээнд хамрагдаж чадахгүй байна.

ДОЛОО.ЗӨВЛӨМЖ.

Асуудлын мөн чанар, цар хүрээг харгалзан Гепатитын D вирусийн эмчилгээнд хэрэглэх зорилгоор импортлох Булевиртид эмийг Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх хуулийн төслийг боловсруулах нь зүйтэй байна.

**НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН ТАЙЛАН**

**Улаанбаатар хот
2024 он**

Гарчиг

Нэг. Ерөнхий зүйл

Хоёр. Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгосон байдал

Гурав. Хуулийн төслөөс үр нөлөөг үнэлэх хэсгийг тогтоосон байдал

Дөрөв. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлсэн байдал

4.1. "Зорилгод хүрэх байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

4.2. "Ойлгомжтой байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

4.4. "Харилцан уялдааг шалгах" шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

Тав. Үр дүнг үнэлж, зөвлөмж өгсөн байдал

5.1. Зөвлөмж

5.2. Дүгнэлт

5.3. Баримтжуулалт

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН ТАЙЛАН

Нэг. Ерөнхий зүйл

Энэхүү үнэлгээний ажлын гол зорилго нь Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийн зохицуулалтад тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулахад оршино.

Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулиар Гепатитын D вирусийн эмчилгээнд хэрэглэх зорилгоор импортлох Булевиртид эмийг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх, барааны жагсаалтыг "Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем /БТКУС/"-ийн ангиллын дагуу батлуулах, хуулийг хэрэгжүүлэх хугацааг зохицуулахаар тусгасан.

Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг Эрүүл мэндийн сайд, Сангийн сайд, болон Хууль зүй, дотоод хэргийн сайдаар батлуулсан үзэл баримтлалд нийцүүлэн боловсруулсан эсэхийг нягталж, хуулийн төсөл батлагдан хэрэгжсэнээр хүний эрх, нийгэм, эдийн засаг, байгаль орчинд ямар үр дагавар, үр нөлөө үзүүлэхийг тооцох, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, салбарын бусад хууль тогтоомжийн харилцан уялдааг тогтоох, хуулийн төслийг ойлгомжтой, хүлээн зөвшөөрөгдөх, практикт хэрэгжих боломжтой байдлаар боловсруулахад зөвлөмж өгөх зорилгоор Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3-т заасан аргачлалын дагуу үр нөлөөний үнэлгээг хийж гүйцэтгэлээ.

Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн хэрэгцээ, шаардлагыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасныг баримтлан Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал"-д нийцүүлэн хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээг дараах үе шаттайгаар зохион байгуулав:

- шалгуур үзүүлэлтийг сонгох;
- хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоох;
- шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
- үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

**Хоёр. Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур
үзүүлэлтийг сонгосон байдал**

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-д заасны дагуу Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгохдоо хуулийн төслийн зохицуулах асуудалтай уялдуулан дараах 2 шалгуур үзүүлэлтийг сонгосон:

- зорилгод хүрэх байдал;
- ойлгомжтой байдал;

Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн “зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийг сонгон авч, дараах 3 шалгах хэрэгслээр тодорхойлж үзэв:

1. Хуулийн төсөлд туссан зүйлүүд тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэж чадах эсэх;
2. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх;
3. Хуулийн төслөөр дэвшүүлсэн зорилгод хүрч чадах эсэх.

“Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн тухайд дараах 3 шалгах хэрэгслээр тодорхойлов:

1. Хуулийг хэрэглэх, хэрэгжүүлэх субъект болон холбогдох бусад байгууллага, аж ахуйн нэгжийн хувьд ойлгомжтой эсэх;
2. Хуулийн төсөл нь бүтэц, хэлбэрийн хувьд логик дараалалтай эсэх;
3. Агуулга, хэл зүй, найруулгын хувьд ойлгомжтой, тодорхой эсэх.

Гурав. Хуулийн төслөөс үр нөлөөг үнэлэх хэсгийг тогтоосон байдал

Сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үр нөлөөг үнэлэхэд хамруулах хэсэг, түүнийг шалгах хэрэгслийг дараах байдлаар тогтоолоо (Хүснэгт 1).

Хүснэгт 1

Д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Шалгах хэрэгсэл
-----	------------------	------------------------	-----------------

1.	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийг бүхэлд нь хамруулах	Хуулийн төсөлд дэвшүүлсэн зорилгод хүрэх боломжтой байдлаар томъёологдож чадсан эсэх болон хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцэж байгаа эсэхийг шалгах
2.	Ойлгомжтой байдал	Хуулийн төслийг бүхэлд нь хамруулах	"Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал"-ын 2 дугаар бүлэгт заасан хуулийн төсөл боловсруулахад тавигдах нийтлэг шаардлага болон 3 дугаар бүлэгт нийцсэн эсэхийг шалгах

Дөрөв. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлсэн байдал

Энэ тайлангийн 3 дугаар бүлэгт сонгосон хэсгүүдэд шалгуур үзүүлэлтүүдийн хүрээнд дараах байдлаар үнэлгээ хийлээ:

4.1. "Зорилгод хүрэх байдлыг судлах" шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийн "зорилгод хүрэх байдал" шалгуур үзүүлэлтийг дараах байдлаар үнэлэв (Хүснэгт 2):

			Хүснэгт 2
Д/д	Шалгуур үзүүлэлт, шалгах хэрэгсэл	Хуулийн төсөлд тусгасан зохицуулалт, арга хэмжээ	Төслийн зүйл, заалт

1.	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төсөлд туссан зохицуулалтууд нь нийгэмд тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэж чадах эсэх	<p>Гепатитын В, D вирусийн эмчилгээнд хэрэглэх Булевиртид эмийн үнэ өндөр байгаатай холбоотойгоор тус эмчилгээ шаардлагатай иргэд эмчилгээнд хамрагдаж чадахгүй байна.</p> <p>Хуулийн төсөл батлагдсанаар дараах зэрэг үр дүн гарна. Гепатитын D вирусийн халдвартай иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж сайжирч, хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаанд багтаж байгаа элэгний хатуурал, элэгний хорт хавдрын шалтгаант нас баралт буурна. Үүний зэрэгцээ иргэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авахад учрах санхүүгийн дарамт буурна.</p>	Хуулийн төслийг бүхэлд нь хамруулах
2.		Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх	<p>Эмийн чанар, аюулгүй байдлын хатуу зохицуулалттай хяналтын байгууллага болох Европын эмийн агентлагаас Булевиртид эмийг эмийн бүртгэлд албан ёсоор бүртгэж, гепатитын В, D вирусийн архаг халдварын эмчилгээнд хэрэглэх зөвшөөрөл олгосон. Үүнтэй уялдуулан манай улс гепатитын В, D вирусийн эмчилгээний заавраа шинэчлэн баталж 2024 оноос мөрдөж эхлээд байна.</p> <p>Булевиртид эм нь 47 амин хүчлээс тогтсон нийлэг эм бөгөөд элэгний эсэд D вирус нэвтрэхийг саатуулах үйлчилгээтэй болно.</p>	Хуулийн төслийг бүхэлд нь хамруулах

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд Гепатитын D вирусийн эмчилгээнд хэрэглэх зорилгоор импортлох Булевиртид эмийг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөхөөр тусгасан байна. Энэ нь Гепатитын D вирусийн халдвар ихэвчлэн гепатитын В вирусийн халдвартай хавсардаг. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-аас хийсэн тооцооллоор манай улсад гепатитын D вирусийн халдвартай 60 гаруй мянган иргэний тодорхой хэсгийг эмчлэх боломж бүрдэх ач холбогдолтой байна.

Хуулийн төслийн үзэл баримтлалд туссан зорилгод тулгуурлан боловсруулсан хуулийн төслийн зохицуулалтад дүн шинжилгээ хийхэд тухайн зохицуулалт, арга хэмжээ нь зорилгод хүрэх боломжтой гэж дүгнэлээ.

4.2. “Ойлгомжтой байдлыг судлах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1-д заасан “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-ын Хоёрдугаар бүлэг “Хуулийн төсөл боловсруулахад тавигдах нийтлэг шаардлага”-т заасан шаардлагыг дараах байдлаар үнэлэв (Хүснэгт 3).

Хүснэгт 3

Хуулийн төслийн эх бичвэрийн асуулгад тавигдах шаардлага		
1.	Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх	Шаардлагыг хангасан.
2.	Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх	Шаардлагыг хангасан.
3.	Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харлцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх	Шаардлагыг хангасан.
4.	Зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх	Шаардлагыг хангасан.
5.	Хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх	-
Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавигдах шаардлага		
6.	Хуулийн төслийн үг хэллэг, өгүүлбэрийг хэл зүй, найруулга, өгүүлбэр зүйн монгол хэл, бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй, товч тодорхой, ойлгоход хялбар байх	Шаардлагыг хангасан.
7.	Бичвэр нь үндсэн агуулгаас хоёрдогч ач холбогдол бүхий ерөнхийгөөс тусгай руу, нийтлэг журмаас тусгай руу гэсэн хэлбэртэй байх	Шаардлагыг хангасан.
Хуулийн төслийн эх бичвэрт хэрэглэх арга, аргачлал		
8.	1.Нэр томьёо хэрэглэх 2.Хуулийн төслийн үг хэллэг сонгох 3.Товчлол хийх	Шаардлагыг хангасан

4.Ишлэл хийх		
Хуулийн төслийн эх бичвэрийг боловсруулахад тавигдах шаардлага		
9.	Хуулийн төслийн эх бичвэрийг боловсруулахад холбогдох эрх зүйн баримт бичгийг баримталсан эсэх	Хуулийн төслийг боловсруулахад Хууль тогтоомжийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал", Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор баталсан "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам"-ыг тус тус баримталсан байна.

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөө үнэлэх аргачлалд заасан дараах стандарт асуултад хариулах замаар хуулийн төслийн уялдаа холбоог бүхэлд нь шалгахыг зорилоо.

Үүнд Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүл мэндийн тухай, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай, Эрүүл ахуйн тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай, Дархлаажуулалтын тухай, Гамшгаас хамгаалах тухай, Хүнсний тухай, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай, зөвшөөрлийн тухай, Зар сурталчилгааны тухай, хууль болон холбогдох бусад хууль, хууль тогтоомжийн актад нийцсэн эсэхийг шалгалаа.

Тав. Үр дүнг үнэлсэн, дүгнэсэн байдал

5.1.Хуулийн төсөлд дэвшүүлсэн зорилтын хүрээнд хамаарах зохицуулалтыг сонгон авч үр нөлөөг үнэлэхэд Гепатитын D вирусийн эмчилгээнд хэрэглэх зорилгоор импортлох Булевиртид эмийг Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх хуулийн төслийг боловсруулах нь зүйтэй байна.

Төслийн ойлгомжтой байдлыг хуулийн төсөл, түүний зохицуулалтыг нэг мөр ойлгож, хэрэгжүүлэх боломжтой байгаа эсэх, Хууль тогтоомжийн тухай хууль болон Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалыг баримталсан эсэхийг шалгасан. Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалыг баримталсан эсэхийг дүгнэхэд энэ төрлийн зөрчил тогтоогдоогүй болно.

5.2. Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийн үр нөлөөг сонгосон дээрх 2 үзүүлэлтээр үнэлэхэд хуулийн төслийн үзэл баримтлалаар тодорхойлсон зохицуулах харилцаа, хамрах хүрээг хангасан байна. Мөн энэхүү хууль нь хэрэгжих боломжтой хуулийн төслийн томъёолол ойлгомжтой, хоёрдмол утга санаа агуулаагүй, бусад хууль тогтоомж болон тухайн хуулийн зүйл, заалт нь давхардаагүй, зөрчилдөөгүй гэж дүгнэж байна.

--- оОо ---

**ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН
ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦОО**

/Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хууль/

УЛААНБААТАР ХОТ 2024 ОН

ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

НЭГ.ЕРӨНХИЙ ҮНДЭСЛЭЛ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно” гэж заасан. Энэ дагуу Гепатитын D вирусийн эмчилгээнд хэрэглэх зорилгоор импортлох Булевиртид эмийг Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-ыг баримтлан зардлын тооцоог гаргав.

Гепатитын D вирусийн эмчилгээнд хэрэглэх зорилгоор импортлох Булевиртид эмийг Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийг хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардал, ачааллыг тооцож, үүнийг хялбарчлах, бууруулах талаар санал боловсруулахад энэхүү тайлан чиглэгдсэн.

ХОЁР.ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

Гепатитын D вирусийн эмчилгээнд хэрэглэх зорилгоор импортлох Булевиртид эмийг Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл батлагдсанаар хуулийн этгээдэд гүйцэтгэх үүрэг тусгагдаагүй. Иймд уг хуулийн төсөл батлагдсанаар хуулийн этгээдэд цаашид зардал үүсгэх эсэхийг тооцоолох шаардлагагүй гэж үзлээ.

ГУРАВ. ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДАЛ

Гепатитын D вирусийн эмчилгээнд хэрэглэх зорилгоор импортлох Булевиртид эмийг Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл батлагдсанаар иргэнд гүйцэтгэх үүрэг тусгагдаагүй. Иймд уг хуулийн төсөл батлагдсанаар иргэнд цаашид зардал үүсгэх эсэхийг тооцоолох шаардлагагүй гэж үзлээ.

ДӨРӨВ. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРДЛЫН ТООЦОО

4.1. Төрийн байгууллагын чиг, үүргийг тодорхойлох

Аргачлалын дагуу Гепатитын D вирусийн эмчилгээнд хэрэглэх зорилгоор импортлох Булевиртид эмийг Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөлд туссан чиг үүргийг хэрэгжүүлэх төрийн байгууллагыг хүснэгт 1-ээр харуулав. Байгууллагыг сонгохдоо Аргачлалын 4.3.2-т “байгууллагыг сонгохдоо тухайн ажил, үйлчилгээнд хамааралтай бүх байгууллагыг биш голлон үүрэг гүйцэтгэх байгууллагыг сонгоно;” гэсний дагуу голлох үүрэг гүйцэтгэх байгууллага болох эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагыг сонгон зардлын тооцоо хийсэн.

Хүснэгт 1.Хуулийн төсөлд туссан төрийн байгууллагад шинээр нэмэгдээж байгаа чиг үүрэг, түүнийг хэрэгжүүлэх байгууллага.

Хуулийн зүйл, заалт	Үүргийн мэдээлэл	Чиг үүргийг хэрэгжүүлэх байгууллага
Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан эмийн жагсаалтыг “Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем /БТКУС/”-ийн ангиллын дагуу Монгол Улсын Засгийн газар батална	Үүрэгжүүлсэн заалт	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага)

Хүснэгт 2. Төрийн байгууллагын зардлыг тодорхойлсон байдал

Хуулийн зүйл, заалт	Үүргийн мэдээлэл	Хугацаа /цаг/
Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан эмийн жагсаалтыг “Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем /БТКУС/”-ийн ангиллын дагуу Монгол Улсын Засгийн газар батална	Одоогийн мөрдөгдөж буй хууль тогтоомжийн зохицуулалт	-

Гепатитын D вирусийн эмчилгээнд хэрэглэх зорилгоор импортлох Булевертид эмийг Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөлд тусгагдсан чиг үүргийг дараах байгууллагууд гүйцэтгэхээр байна. Үүнд:

1. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;
2. Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага;
3. Халдварт өвчин судлалын үндэсний төв;

Гепатитын D вирусийн эмчилгээнд хэрэглэх зорилгоор импортлох Булевертид эмийг Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн хэрэгжилттэй холбогдох төрийн байгууллага энэхүү үүргийг хэрэгжүүлэх нь холбогдох этгээдийн одоогийн байгаа орон тоо, төсөв, зардалд нөлөөлөхгүй гэж үзсэн.

4.2. Гарах зардлыг тооцох

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 22 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 222 дугаар тогтоолоор Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрыг байгуулсан бөгөөд нийт 132 орон тоотой үйл ажиллагаа явуулж байна. Эрүүл мэндийн сайдын багцын төсвийн харьяа байгууллага болох Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар батлагдсан орон тоо, төсөвтөө багтаан хуулийн төсөл батлагдан гарахтай холбоотой чиг үүргийг хэрэгжүүлэх боломжтой.

4.3. хувилбарыг нягталж зардлыг бууруулах боломжийг эрэлхийлэх.

Тус хуулийн төсөл батлагдсантай холбоотой тухайн эмийн бүртгэл, импортын мэдүүлэг, хадгалалт, тээвэрлэлтийн байдалд хяналт тавих зэрэг чиг үүргийг эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага гүйцэтгэх тул хүний нөөцийн нэмэлт зардал үүсэхгүй.

ТАВ.ДҮГНЭЛТ, САНАЛ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4- т заасан аргачлалын дагуу тодорхойлно” гэж заасны дагуу Гепатитын D вирусийн эмчилгээнд хэрэглэх зорилгоор импортлох Булевиртид эмийг Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ыг баримтлан зардлын тооцоог хийж үзлээ.

Тус хуулийн төсөл батлагдсантай холбоотой тухайн эмийн бүртгэл, импортын мэдүүлэг, хадгалалт, тээвэрлэлтийн байдалд хяналт тавих зэрэг чиг үүргийг эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага гүйцэтгэх тул одоогийн батлагдсан орон тоо, төсөвтөө багтаан хэрэгжүүлэх боломжтой гэсэн тооцоо гарсан.

Хуулийн төсөлд Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулахаар заасан нь тухайн төрийн байгууллагын албан хаагчийн ажлын байрны тодорхойлолтод тусан чиг үүрэгт хамаарах тул тогтоолын төсөл боловсруулахад зардал гарахгүй.

-----oOo-----

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. Хууль тогтоомжийн тухай хууль;
2. Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоол.

---oOo---

**ГЕПАТИТЫН D ВИРУСИЙН ЭМЧИЛГЭЭНД ХЭРЭГЛЭХ ЗОРИЛГООР ИМПОРТЛОХ БУЛЕВИРТИД ЭМИЙГ НЭМЭГДСЭН ӨРТГИЙН
АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ТӨРИЙН БОЛОН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН
САНАЛЫН ТОВЬБЕГ**

2024.04.09-ний өдөр

Д/д	Яамд	Ирүүлсэн санал	Саналыг тусгасан эсэх	Саналыг тусгасан байдал, тайлбар
1	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар	Тусгайлан өгөх саналгүй.	-	-
2	Монголын эм зүйн байгууллагуудын нэгдсэн "ЭМ" холбоо	Хуулийн төслийг дэмжиж байна. НӨАТ-ыг зөвхөн гааль дээр чөлөөлөөд үр дүнд хүрэхгүй, борлуулалтын үйл ажиллагааны НӨАТ-ыг давхар чөлөөлсөн тохиолдолд үр дүнд хүрнэ. Олон жил яригдаж байгаа зайлшгүй шаардлагатай эм, тэдгээрийн түүхий эдийг гаалийн болон НӨАТ-асс чөлөөлөх хүсэлтийг бодит ажил болгох Эмийн үйлдвэр, эмийн чанарын хяналтын лабораторийн багаж, тоног төхөөрөмжийг гаалийн болон НӨАТ-асс чөлөөлөх	Тусгаагүй	Энэ хуулийн төсөлтэй хамааралгүй санал тул тусгаагүй.
3	Олон нийтээс санал авсан байдал	Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсэгт заасны дагуу Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай болон Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөлд санал авахаар Эрүүл мэндийн яамны цахим хуудсанд (https://moh.gov.mn/news/6929) 2024 оны 03 дугаар сарын 07 -ны өдөр мэдээлэл оруулсан. 2024 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн байдлаар санал ирээгүй. Зарыг хавсралтаар оруулав.	Тусгаагүй	Энэ хуулийн төсөлтэй хамааралгүй санал тул тусгаагүй.



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ

МОНГОЛ УЛСЫН
ЗАСГАГАЧЛААР

ТҮГЭЭМЭЛ АСУУЛТ
Туслах

ХОЛБОО БАРИХ
Залгах

САНАЛ, ХҮСЭЛТ
Нэгтгэх

НҮҮР ЯАМНЫ ТУХАЙ ~ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ~ ЭРХ ЗҮЙ ~ МЭДЭЭ ~ ИЯ ТОД ~ ШИЛЭН ДАНС СТАТИСТИК ХЯНАЛТ ЭМДС НЭЭЛТЭЙ ӨГӨГДӨЛ 11.11



ХУУЛИЙН ТӨСӨЛД САНАЛ АВЧ БАЙНА

📅 2024-03-07 11:19:00

A- A+ A-

ХУУЛИЙН ТӨСӨЛД САНАЛ АВЧ БАЙНА

Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсэгт заасны дагуу Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай болон Нэмэгдсэн өргийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөлд санал авч байна. Хуулийн төсөлтэй танилцаж, саналаа 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн дотор Эрүүл мэндийн яамны Бодлого төлөвлөлтийн газарт ирүүлнэ үү.

Эрүүл мэндийн яам

2024 оны 03 дугаар сарын 07 -ны өдөр

1. Товч танилцуулга
2. Хуулийн төсөл
3. Зардлын тооцоо
4. Үзэл баримтлал
5. Тандан судалсан судалгааны тайлан
6. Үр нөлөөний үнэлгээний тайлан

📧 Жиргах

Мэдээний ангилал

Цаг үеийн мэдээ

Коронавируст халдвар (COVID-19)-ын үед эмнэлгийн тусламжийн бэлэн байдлыг хангахад чиглэсэн заавар зөвлөмж

Коронавируст халдвартай холбоотой журам, заавар

Хүлээгдлийн мэдээ

Сошиалд дагаарай



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН
ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР**


Юу Би Эйч төв, 8 давхар, Энхтайваны өргөн чөлөө 23,
1 дүгээр хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14210
Утас: 26 01 82

2024.04.05 № 01/527
танай 2024.04.01 -ны № 4/1295 -Т

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ
БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗАРТ**

Гепатитын Д вирусийн эмчилгээнд хэрэглэх зорилгоор импортлох Булевиртид эмийг Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөлд тусгайлан өгөх саналгүй болно.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ *Ш. Энхтуяа* Ш.ЭНХТУЯА



1424 160534



Монголын Эм Зүйн Байгууллагуудын Нэгдсэн
“ЭМ” Холбоо ТББ

Монгол улс, Улаанбаатар хот, Сонгинохайрхан
дүүрэг, 29-р хороо

Үйлдвэрчний эвлэлийн гудамж

Утас: 99900458, 99098752

Е-мэйл: mezbnch@gmail.com

2024.04.05 № 30

Танай _____-ны № 41295

Г ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ БОДЛОГО, Т
ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗАР-Т

Г

Санал хүргүүлэх тухай

Г

Гепатитын Д вирусийн эмчилгээнд хэрэглэх зорилгоор импортлох Булевиртид эмийг гаалийн болон НӨАТ-аас чөлөөлөх тухай хуулийн төсөлтэй танилцаад уг төслийг дэмжиж байгаагаа илэрхийлж байна. Мөн дараах санал хүсэлтийг хүргүүлж байгааг хүлээн авна уу.

1. НӨАТ-ыг зөвхөн гааль дээр чөлөөлөөд үр дүнд хүрэхгүй, борлуулалтын үйл ажиллагааны НӨАТ-ыг давхар чөлөөлсөн тохиолдолд үр дүнд хүрнэ.
2. Олон жил яригдаж байгаа зайлшгүй шаардлагатай эм, тэдгээрийн түүхий эдийг гаалийн болон НӨАТ-аас чөлөөлүүлэх хүсэлтийг бодит ажил болгох.
3. Эмийн үйлдвэр, эмийн чанарын хяналтын лабораторийн багаж, тоног төхөөрөмжийг гааль болон НӨАТ-аас чөлөөлүүлэх.

ХҮНДЭТГЭСЭН,
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



И.БАЛЖИННЯМ

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын холбогдох байнгын хороо болон Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх үед Эрүүл мэндийн яамнаас оролцох албан хаагчдын нэрс

Нэр	Албан тушаал	Албаны утас	Гар утас
П.Оюунцэцэг	Бодлого төлөвлөлтийн газрын дарга	(51) 264454	99996434
А.Өнөржаргал	Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газрын дарга	(51) 261557	99194784
Л.Лувсан	Санхүү, эдийн засгийн газрын дарга	(51) 260474	99992290